

Монгол Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын 2002 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэв

## **ИРГЭДИЙН НАСЫГ ТОГТООЖ БАЙГАА ШҮҮХИЙН ПРАКТИКИЙН ТУХАЙ ЗӨВЛӨМЖ**

Төрийн захиргааны байгууллага, шүүхийн хооронд иргэд нас тогтоолгох асуудлаар олон дахин явж чирэгдэх болсноос Иргэний бүртгэлийн байгууллага, иргэдээс Дээд шүүхэд удаа дараа санал, гомдол ирж байна. Үүний шалтгааныг судлан үзвэл захиргааны журмаар шийдвэрлэх асуудлыг шүүх авч хэлэлцэх, шүүх нас тогтоолгох хүсэлтийг харъяаллын бус гэдэг үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж байгаагаас үүдэлтэй байна.

Нийслэлийн шүүхээс хийсэн судалгаагаар дүүргийн шүүхүүд 1999 онд 221, 200 онд 498, бүгд 719 хэрэг шийдвэрлэсний дотор 1951 оноос өмнө төрснийг тогтоосон 310, 1951 оноос хойш төрснийг тогтоосон 409 хэрэг байна. Нийт шийдвэрлэсэн хэргийн 66, хувийг төрсөн онс, сар, өдөртэй нь тогтоож, 23,5 хувьд шинжээч томилж, 1,6 хувь нь засвартай болон буруу бичигдсэн төрсний гэрчилгээтэй, 37,5 хувь нь иргэний паспорттай буюу регистрийн дугаар нь тодорхой хэрэг шийдвэрлэжээ.

Энэ төрлийн хэргийг сүүлийн 2 жилийн байдлаар хянах явцад 45 хэрэг буюу 6,2 хувьд Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн эсэргүүцэл бичигдэж, хяналтын шатны иргэний шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэнээс анхан шатны шүүхийн 37 шийдвэр хүчингүй болж, 3 шийдвэр өөрчлөгдөж, 5 иргэний хүсэлтийг хэрэгсэхгүй болгожээ.

Шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 36-46 дугаар зүйлүүдэд заасны дагуу нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүйгээс анхан шатны шүүхийн шийдвэр хүчингүй болох гол үндэслэл болж байна. Тухайлбал шүүхийн үнэлсэн нотлох баримт хуулийн шаардлага хангаагүй, хуулбар хувь байх, гэрчид хууль сануулж мэдүүлэг авч, тэмдэглэл хөтлөөгүй, “тодорхойлолт” гэсэн бичиг баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлдэг, шинжээчийн дүгнэлт гаргуулдаггүй, үйл баримтыг цаг хугацааны хувьд зөв тооцдоггүй зэрэг шалтгаантай байжээ.

Дээд шүүхээс нийслэлийн 8 дүүргийн шүүхээр 2001 оноос хойш шийдвэрлэсэн нас тогтоолгох тухай иргэний 20 хэргийг судлан үзвэл иргэд гурван гол шалтгаанаар нас тогтоолгох хүсэлтийг шүүхэд гаргажээ.

1. 50-60 наснаас дээш настай хүмүүс янз бүрийн шалтгаанаар насаа 1-5 насаар дарж явсаар 55 буюу тэтгэвэрт гарах насанд хүрч тэтгэврээ тогтоолгох эрхтэй болсон үедээ төрсөн он, сар, өдөр, насыг тодорхойлох гол баримт бичиг нь тухайн иргэний настай зөрчснөөс шүүхэд хандан төрсөн он, сар, өдөр, насаа үнэн зөвөөр тогтоолгохыг хүссэн хэрэг бүх хэргийн 40 хувийг эзэлж байна.

2. Мөн төрсний гэрчилгээ болон бусад баримт бичиг байхгүй, хаяж үрэгдүүлсэн эсвэл Улсын иргэний бүртгэл мэдээллийн архиваас шүүгээд олдохгүй байгаа.

3. Төрсний гэрчилгээ буюу иргэний паспорт /үнэмлэх/-д төрсөн он, сар, өдөр буруу бичигдсэн, засвартай, эсвэл төрснийг батлах ямар ч баримт бичиггүй тул шүүхэд хандаж байна.

Улсын хэмжээнд 2000 оноос иргэний паспортыг иргэний шинэ үнэмлэхээр солих болсонтой холбогдон иргэд насаа зөв тогтоолгохыг хүсэх явдал мэдэгдэхүйц нэмэгдсэн нь судалгаанаас харагдлаа.

Шүүхээс иргэдийн нас тогтоолгох тухай хүсэлтийг хангах, хэрэгсэхгүй болгохдоо:

1. Улсын төв архивын лавлагаа
2. Улсын иргэний бүртгэл мэдээллийн төвийн магадлагаа
3. Он дарааллын хүн амын тооллогын улсын бүртгэл
4. Шүүх эмнэлгийн шинжээчийн дүгнэлт, акт
5. Гэрчүүдийн мэдүүлэг зэргийг гол нотлох баримт болгожээ.

Шүүх энэ төрлийн хэргийг шийдвэрлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 138-1-3, 138-1-7 дагуур зүйлийг хэрэглэжээ. Харин нэг хэрэг дээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120, 128, 54 дүгээр зүйлээр тухайн нэхэмжлэл нь шүүхэд харъяалах хэрэг биш гэдэг үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ. Үүнээс дүгнэлт хийвэл шүүх, шүүгч нарын дунд нас тогтоолгох хүсэлт нь шүүхийн эрх хэмжээний асуудал мөн, биш гэсэн өөр өөр ойлголттой байгаа нь харагдаж байна.

Иймд шүүх, захиргааны байгууллагын эрх зүйн ойлголтыг нэгтгэх, иргэдийг чирэгдүүлэхгүй байх, шүүгч нарыг нэгдсэн ойлголттой болгох зорилгоор Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 4 дүгээр заалтыг баримтлан Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас ЗӨВЛӨХ нь

1. Иргэний нас тогтоолгох хүсэлтийг шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 68 дугаар зүйл, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1962 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 07 тоот тогтоолоор баталсан “Иргэдийн насыг хууль ёсоор тооцох тухай” журамд заасан хугацаа тоолох ерөнхий журмын дагуу “хугацааг хуанлийн он, сар, өдрөөр буюу ямар нэгэн зүйл явдал /төрөх/ бий болсноос эхэлж тоолох ёстой байвал уг тогтоосон он, сар, өдрөөс эхлэн тоолно” гэсэн заалт, түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 136 дөгөөр зүйлд эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох хэргийг шүүх онцгой ажиллагааны журмаар хэлэлцэнэ гэж заасныг үндэслэн мөн хуулийн 138 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дугаар заалт “тогтоох журмыг нь хуульд заагаагүй эрх зүйн ач холбогдол бүхий бусад үйл явдлыг шүүх тогтооно” гэсэн ёсоор иргэдийн төрсөн он, сар, өдөр, насыг шүүх тогтооно.

2002 оны 9 дүгээр сарын 1-ээс хойш Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай шинэ хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэг, 135 дугаар зүйлийн 135.2.13 дахь заалт ёсоор иргэний насыг онцгой ажиллагааны журмаар шүүх тогтоож байх болно.

2. Иргэдийн хүсэлтээр төрсөн он, сар, өдөр тогтоохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 138 дугаар зүйлийн 2-т заасан “...бичиг баримтыг өөр журмаар олж авах боломжгүй буюу үрэгдсэн бичиг баримтыг сэргээх боломжгүй бол шүүх тогтооно” гэсэн хуулийн шаардлагыг энэ төрлийн хэрэг шийдвэрлэхдээ удирдлага болговол зохино.

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 138 дугаар зүйлийн 3 дахь заалт нь төрөлтийг бүртгүүлсэн байдал,

-Мөн зүйлийн 4 дэх заалтын иргэний паспорт, гэр бүлийн байдлыг бүртгэх байгууллагаас олгосон гэрчилгээнээс бусад эрх олгосон ямар нэг баримт бичигт дурдсан, овог нэр, төрсөн он, сар, өдөр нь паспорт, төрөлтийн тухай гэрчилгээнд бичигдсэнтэй тохирохгүй байвал түүний жинхэнэ эзэмшүүгч нь мөн эсэхийг шүүх тогтооно гэж ойлгох нь зүйтэй.

Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 136 дугаар зүйлд эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох хэргийг шүүх онцгой ажиллагааны журмаар хэлэлцэнэ гэж заасныг үндэслэн мөн хуулийн 138 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дугаар заалт “тогтоох журмыг нь хуульд заагаагүй эрх зүйн ач холбогдол бүхий бусад үйл явдлыг шүүх тогтооно” гэсэн ёсоор иргэдийн төрсөн он, сар, өдөр, насыг тогтоохдоо энэ зүйлийг баримтлана.

-Мөн энэ төрлийн хэрэг шийдвэрлэхдээ 1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан “Иргэний бүртгэлийн тухай” Монгол Улсын хуулийг нарийвчлан судалж, иргэний бүртгэл мэдээллийн албаны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг мэдэх шаардлагатай.

3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 41 дүгээр зүйлийн шаардлагыг хангасан нотлох баримтанд үндэслэн хэргийг шийдвэрлэх “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хуулийн анхан шатны шүүхийн үйл ажиллагааг зохицуулсан зарим зүйл, хэсгийг тайлбарлах тухай” Монгол Улсын Дээд шүүхийн 1995 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 80 дугаар тогтоолын 10, 11, 12 дугаар заалтыг нотлох баримт бүрдүүлэхдээ мөрдлөгө болгож байх хэрэгтэй.

-Иргэдээс бичсэн “тодорхойлолт”-ыг шүүх шийдвэртээ нотлох баримтын хэмжээнд үнэлдэг буруу практикийг зогсоож, гэрчид хууль сануулан мэдүүлэг авч, тэмдэглэл хөтлөх ажиллагааг хэвшил болгох.

-Үндэсний төв архивын лавлагаагаар нас нь тогтоогдсоноос бусад нөхцөлд шүүх эмнэлгийн шинжээчийн дүгнэлт гаргуулж байх, шаардлагатай тохиолдолд криминалистик, биологийн шинжээчийн дүгнэлтийг давхар гаргуулж байх.

-Нотлох баримтанд иргэний төрсөн он, сар, өдрийг тогтооход ач холбогдол бүхий хөдөлмөрийн болон нийгмийн халамжийн дэвтэр, МҮЭ, МХЗЭ зэрэг олон нийтийн байгууллагын гишүүний бат илэрхийлэх, үнэмлэх, тухайн үед бичигдсэн түүх намтар, анкет, зураг, эрүү, иргэний хэрэгт асуугдсан байдал болон бусад үйл баримтаар цаг хугацааны хувьд тохирч, давхар нотлогдож байгаа эсэхийг нягтлах.

-Монгол Улсын хэмжээнд хүн амын тооллого 1918, 1924, 1933, 1944, 1947, 1956, 1963, 1969, 1979, 1989, 2000 онуудад явагдсан байх тул тухайн хүний гаргасан хүсэлтийг хүн амын тооллогын материалаас тодруулж байх.

-Үндэсний төв архив, орон нутгийн архив, иргэний бүртгэлийн архив, төрөх газрын лавлагаа, тодорхойлолтыг авч байхын зэрэгцээ шаардлагатай үед шүүх бүрэлдэхүүн газар дээр нь бичиг баримтын үзлэг хийж тэмдэглэл хөтөлж байхыг зөвлөж байна.

4. Иргэний үнэмлэх, бусад бичиг баримтаа хаяж үрэгдүүлсэн буюу засвартай нөхцөлд Иргэний бүртгэл мэдээллийн төвөөс олгосон “лавлагаа” болон бусад нотлох баримтаар регистрийн дугаар нь тодорхой бол “Иргэний бүртгэлийн тухай” хуулийн дагуу Иргэний бүртгэл мэдээллийн албаны шийдвэрлэх эрх хэмжээний асуудал гэдэг үндэслэлээр хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж байх нь зүйтэй.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН  
ШҮҮГЧ

Р.ЖАМЪНЧОЙЖИЛ

ШҮҮГЧ

Б.ЦОГНЯМ